



**ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2013 оны 11 сарын 20 өдөр

Дугаар 204

Мандалговь

**Хөрөнгө худалдах тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77,3. Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2010 оны 22 тоот тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасахад баримтлах журам”-ын 3 дугаар зүйлийн 3.1 “б” 3.2.6-гийн “а”, 4 дүгээр зүйлийн 4.1 дэхь заалтуудыг үндэслэн Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээс **ТОГТООХ НЬ:**

1. Сайнцагаан сумын ЗДТГ-ын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 1’826’000 төгрөгийн анхны өртөгтэй, 578’200 төгрөгийн үлдэх өртөгтэй аж ахуйн складны худалдах доод үнийг 500’000 /таван зуун мянган/ төгрөгөөр тогтоон худалдахыг зөвшөөрсүгэй.

2. Худалдагдсан хөрөнгийг зохих журмын дагуу данс бүртгэлээс хасахыг Сайнцагаан сумын ЗДТГ-ын дарга /Б.Оюунчимэг/-д даалгасугай.

3. Дуудлага худалдааг журмын дагуу зохион байгуулж, хөрөнгө худалдсанаас орох орлогыг Төрийн сангийн хөрөнгө борлуулсны орлогын 080000962 тоот дансанд төвлөрүүлэхийг Орон нутгийн өмчийн алба /П.Очирбат/-д үүрэг болгосугай.

ДАРГА



С.БУДЖАВ